

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРООНДЫН МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ
ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГҮНЭЛСЭН ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилт нь Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийн хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохиорох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГҮНЭЛЭХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс доорх 4 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхийг үнэлнэ.

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томьёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийнэ.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл батлагдсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт үүсгэх зардал, ачааллыг Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тооцно.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэхийг, хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэхийг, хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэхийг, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэхийг, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэхийг, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэхийг, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэхийг, хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэхийг, хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэхийг, хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэхийг, хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэхийг тус тус үнэлнэ.

Сонгож аваагүй шалгуур үзүүлэлтууд болох Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд бий эсэхийг үнэлдэг бол, хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх этгээдүүд хүлээн зөвшөөрөх эсэхийг тус тус үнэлдэг.

Иймд дээрх шалгуур үзүүлэлтуудийн хүрээнд үнэлэх харилцаанууд нь энэ хуулийн төслөөр шинээр зохицуулагдаж байгаа харилцаа биш хуулийн зөрчлийг арилгах хүрээнд хийгдэж байгаа тул эдгээр шалгуур үзүүлэлтуудийг сонгосонгүй.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхийг хуулийн төслийн "1 дүгээр зүйлийн "Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах" тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай" гэх заалтыг сонгож байна.

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж боловсруулагдсан эсэхийг хянах зорилгоор төслийг бүхэлд нь сонгож байна.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тусгайлан гаргах тул энэхүү үр нөлөөний үнэлгээнд оруулаагүй болно.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хурээнд хуулийн үр нөлөөг үнэлэхэд тухайн хуулийг төслийг бусад хуультай нийцэх байдлыг шалгах тул төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь сонгож байна.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул энэ үе шатанд тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг доорх хүснэгтэд үзүүлж байна. Үүнд:

| № | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|----|-----------------------|---|--------------------------------|
| 1. | Зорилгод хүрэх байдал | 1 дүгээр зүйл | Зорилгод дүн шинжилгээ хийх |
| 2. | Ойлгомжтой байдал | Хуулийн төсөл бүхэлдээ | Ойлгомжтой байдлыг шалгах |
| 3. | Зардал | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно. | Зардлын тооцоо хийх |
| 4. | Харилцан уялдаа | Хуулийн төсөл бүхэлдээ | Хуулийн төслийн холбоог шалгах |

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлж байна:

1. Зорилгод дүн шинжилгээ хийх

Хуулийн төслийн үзэл баримтлал 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 48 дугаар “Гарын үсэг зурах эрх олгох тухай” захирамжийн дагуу “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Загийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Эрчим хүчний сайд гарын үсэг зурсан. Иймд уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Эрчим хүчний салбарын станцууд 2022-2023 оны өвлийн их ачааллыг нөөц тоноглолгүй, хүчин чадлаараа ажиллаад ч ачааллыг бүрэн хааж чадаагүй байна. Тухайлбал 2023.01.24-нд 1474 МВт хүрэх үед систем эх үүсвэрийн дутагдалд орж 26.5 МВт-ын хэрэглээг хязгаарлаж, 52.5 МВт-ын хөнгөлөлт хийсэн тухайн өдрийг давсан байна. Энэ нь чадлын дутагдалд орсон, цаашид ойрын 3-4 жилд эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай болсныг харуулж байна.

Монгол Улсын эрчим хүчний системийн Оросын Холбооны Улсаас авах импортын чадал дээд хэмжээндээ тулсан, дотоодын ямар ч нөөцгүй, цаашид байдал бүр хүндэрвэл БНХАУ-аас импортын цахилгаан эрчим хүч авахаас өөр сонголтгүй байдалд орохоор байна.

Иймээс Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эх үүсвэрийн 5, өргөтгөлийн 6 төслийг цаг алдалгүй эхлүүлж, 500-600 МВт-аар суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тухай үзэл баримтлалд дурдагдсан байна.

2. Ойлгомжтой байдлыг шалгах

Хуулийн төслийн зохицуулалт нь найруулга, хэлзүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд дор дурдсанаар нарийвчлан үнэлж байна:

| Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага | |
|---|--|
| Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт | Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал |
| 29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх | Шаардлага хангасан. |
| 29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх | Шаардлага хангасан. |
| 29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх | Шаардлага хангасан. |
| 29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх | Шаардлага хангасан. |
| 29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зэрчилгүй байх | Шаардлага хангасан. |
| 29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх | Шаардлага хангасан. |

| | |
|--|---------------------|
| 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх | Шаардлага хангасан. |
| 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт | Шаардлага хангасан. |
| 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх | Шаардлага хангасан. |
| Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага | |
| 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх | Шаардлага хангасан |
| 30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх | Шаардлага хангасан |
| 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих | Шаардлага хангасан |
| 30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх | Шаардлага хангасан |
| 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх | Шаардлага хангасан |

3. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоож байна:

| | |
|---|---|
| Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх | Тийм |
| Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх | Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна. |
| Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх | Тус хуулийн төсөлд нэр томьёог тайлбарласан зохицуулалт тусгагдаагүй. |
| Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх | Тийм |
| Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх | Үгүй |
| Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх | Тийм |
| Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх | Үгүй |
| Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх | Үгүй |
| Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх | Үгүй |
| Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх | Үгүй |
| Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх | Тийм |
| Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх | Үгүй |
| Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх | Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна. |
| Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | Үгүй |
| Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | Үгүй |
| Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх | Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна. |

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат нь үр дүнг баримтжуулах, үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн дарааллаар явагдана.

1. Үр дүнг баримтжуулах

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг үндэслэсэн.

2. Үнэлэх

Хуулийн төслийн үр нөлөөг хэрхэн үнэлснийг шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж байна.

A. Зорилгод хүрэх байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хуулийн төслийн зохицуулалттай харьцуулан судалсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь үндэслэл, шаардлагыг хангаж байна гэж үзсэн.

B. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд тус тус нарийвчлан үнэлснээс хуульд заасан шаардлага хангасан гэж үзсэн.

В. Харилцан уялдаа

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалд заасан асуултуудад хариулж, уялдаа холбоог хангасан гэж үзсэн.

Зөвлөмж

Энэхүү үнэлгээг “Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Энэхүү үнэлгээг эдгээр хуулийн төсөлд хийхэд сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томьёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн соёрхон батлах тухай хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ